



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тариат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2026/012-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.25 № 164
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ТАРИАТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА Н.ЧИНБАТ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Тариат сумын сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Архангай аймгийн Тариат сумын сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ-ийн тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэгтгэсэн байна.

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан 3,509,765.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,824,482.0 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 685,283.6 мянган төгрөг зарцуулагдаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тариат сумын Засаг дарга нь 2025 онд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээгээр 15 үндсэн зорилтын хүрээнд 106 арга хэмжээг

хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 78.7 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,197,656.92	2,706,734.24
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	675,951.89	2,197,200.16
3	АВЛАГА	442,837.71	401,479.11
4	БАРАА МАТЕРИАЛ	74,233.32	108,054.97
5	НӨӨЦИЙН БАРАА	4,634	0.0
6	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,321,907.26	3,138,502.95
7	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,321,907.26	3,138,502.95
8	Биет хөрөнгө	3,284,955.09	3,101,550.78
9	Биет бус хөрөнгө	36,952.17	36,952.17
10	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	4,519,564.18	5,845,237.19
11	НИЙТ ӨР ТӨЛБӨР	24,423.25	17,641.28
12	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	24,423.25	17,641.28
13	Өглөг	24,423.25	17,641.28
14	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,495,140.93	5,827,595.91
15	Засгийн газрын хувь оролцоо	4,495,140.93	5,827,595.91
16	Засгийн газрын оруулсан капитал	377,027.42	377,027.42
17	Хуримтлагдсан үр дүн	3,753,692.37	5,097,123.49
18	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	364,421.13	353,445
19	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	4,519,564.18	5,845,237.19

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,327,454.58	4,202,749.32
2	ТАТВАРЫН ОРЛОГО	1,056,637.01	1,145,449.72
3	Орлогын албан татвар	756,599.02	716,010.77
4	Хувь хүний орлогын албан татвар	756,499.02	769,572.93
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-54,831.51
6	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	100	1,269.34
7	Хөрөнгийн албан татвар	102,154.66	114,220.26
8	Бусад татвар, төлбөр, хураамж	197,883.33	315,218.7
9	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	696,468.31	3,057,299.6
10	Тусламжийн орлого	0.0	1,632,788.43
11	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,574,349.26	0.0

Архангай аймгийн Тариат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,485,339.54	2,814,935.44
13	УРСГАЛ ЗАРДАЛ	2,465,339.54	2,814,935.44
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,387,525.64	2,795,872.44
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	801,141.72	887,915.88
16	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,804.06	112,329.34
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	652,662.21	726,843.97
18	Хангамж, бараа материалын зардал	55,296.21	61,383.93
19	Нормативт зардал	0.0	400
20	Эд хогшил, урсгал засварын зардал	157,051.75	395,513.53
21	Томилолт, зочны зардал	15,270.5	20,199.8
22	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	140,269.34	172,692.56
23	Бараа үйлчилгээний бусад зардал	468,029.86	418,593.45
24	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,813.9	19,063
25	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,000	0.0
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	842,115.03	1,387,813.88
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	402,368.61	79,782.15
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-402,368.61	-79,782.15
29	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	439,746.43	1,308,031.73

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,854,348.96	4,351,634.03
2	ТАТВАРЫН ОРЛОГО	1,056,637.01	1,145,449.72
3	Орлогын албан татвар	756,599.02	716,010.77
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-54,831.51
5	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	100	1,269.34
6	Хөрөнгийн албан татвар	103,528.96	114,220.26
7	Бусад татвар, төлбөр, хураамж	196,509.03	315,218.7
8	Бусад нийтлэг төлбөр, хураамж	44,599.49	46,729.3
9	Газрын төлбөр	14,489.86	47,230.5
10	Байгалийн нөөц ашигласны төлбөр	137,419.68	221,258.9
11	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	223,362.69	3,206,184.31
12	Нийтлэг татварын бус орлого	223,362.69	1,350,892.55
13	Тусламжийн орлого	0.0	1,632,788.43
14	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	222,503.32
15	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,574,349.26	0.0

Архангай аймгийн Тариат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

16	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,026,885.35	2,411,062.61
17	УРСГАЛ ЗАРДАЛ	2,026,885.35	2,411,062.61
18	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,949,071.45	2,391,999.6
19	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	801,706	888,130.84
20	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,401.16	110,836.29
21	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	628,238.96	710,907.68
22	Хангамж, бараа материалын зардал	51,701.86	60,286.2
23	Нормативт зардал	0.0	535
24	Эд хогшил, урсгал засварын зардал	145,019	388,315.78
25	Томилолт, зочны зардал	15,142.5	20,199.8
26	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	135,451.36	173,365.44
27	Бараа үйлчилгээний бусад зардал	73,410.6	39,422.58
28	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,813.9	19,063
29	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	827,463.62	1,940,571.43
30	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	478,004.51	309,323.15
31	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	478,004.51	309,323.15
32	Дотоод эх үүсвэрээр	478,004.51	309,323.15
33	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-478,004.51	-309,323.15
34	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	95,000	110,000
35	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-95,000	-110,000
36	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	254,459.11	1,521,248.28
37	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	421,492.78	675,951.89
38	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	675,951.89	2,197,200.16

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,055,394.5	4,055,394.5
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,055,394.5	4,055,394.5
3	Тайлант үеийн үр дүн	439,746.43	439,746.43
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,495,140.93	4,495,140.93
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,495,140.93	4,495,140.93
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	35,399.39	35,399.39
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,530,540.32	4,530,540.32
8	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-10,976.14	-10,976.14

Архангай аймгийн Тариат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

9	Тайлант үеийн үр дүн	1,308,031.73	1,308,031.73
10	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,827,595.91	5,827,595.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөөнийт устгалын дараах	Гүйцэтгэлийн устгалын дараах	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,007,270.00	2,496,342.28	1,489,072.28	247.83
11	Татварын орлого	799,378.30	1,145,449.72	346,071.42	143.29
110	Орлогын албан татвар	629,363.80	716,010.77	86,646.97	113.77
1100	Хувь хүний орлогын албан татвар	685,745.00	769,572.93	83,827.93	112.22
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	512,400.00	561,354.01	48,954.01	109.55
110002	Үйл ажиллагааны орлого	31,625.00	33,862.33	2,237.33	107.07
110003	Хөрөнгийн орлого	140,800.00	171,471.39	30,671.39	121.78
110004	Хөрөнгө борлуулсны орлого	500.00	2,465.20	1,965.20	493.04
110008	Шууд бус орлого	420.00	420.00	-	100.00
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(56,500.00)	(54,831.51)	1,668.49	97.05
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(56,500.00)	(54,831.51)	1,668.49	97.05
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	118.80	1,269.34	1,150.54	1068.47
110201	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	118.80	1,269.34	1,150.54	1068.47
113	Хөрөнгийн албан татвар	100,971.40	114,220.26	13,248.86	113.12
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	9,781.10	17,212.26	7,431.16	175.97
113002	Бууны албан татвар	6,840.00	8,010.00	1,170.00	117.11
113004	Малд ногдуулах албан татвар	84,350.30	88,998.00	4,647.70	105.51
118	Бусад татвар, төлбөр, хураамж	69,043.10	315,218.70	246,175.60	456.55
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	29,391.90	46,729.30	17,337.40	158.99
118001	Улсын тэмдэгтийн хураамж	4,773.50	19,437.24	14,663.74	407.19
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	24,618.40	27,292.06	2,673.66	110.86
1181	Газрын төлбөр	13,672.60	47,230.50	33,557.90	345.44
118101	Газрын төлбөр	13,172.60	13,370.50	197.90	101.50
118102	Дуудлага худалдаа	500.00	33,860.00	33,360.00	6772.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	25,978.60	221,258.90	195,280.30	851.70
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	19,566.30	212,796.65	193,230.35	1087.57
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,460.00	3,470.00	2,010.00	237.67
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	3,560.00	3,600.00	40.00	101.12
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1,392.30	1,392.25	(0.05)	100.00
12	Татварын бус орлого	207,891.70	1,350,892.55	1,143,000.85	649.81
120	Нийтлэг татварын бус орлого	207,891.70	1,350,892.55	1,143,000.85	649.81
120003	Торгуулийн орлого	1,000.00	10,175.36	9,175.36	1017.54
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	205,991.70	194,435.70	(11,556.01)	94.39
120009	Бусад орлого	900.00	1,146,281.50	1,145,381.50	127364.61
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,509,765.60	2,824,482.02	685,283.58	80.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,796,288.80	2,567,253.72	229,035.08	91.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,773,023.80	2,548,190.72	224,833.08	91.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	901,732.80	888,130.84	13,601.96	98.49
210101	Үндсэн цалин	505,232.80	509,590.87	(4,358.07)	100.86
210102	Нэмэгдэл	310,800.00	318,858.64	(8,058.64)	102.59

Архангай аймгийн Тариат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210104	Урамшуулал	85,700.00	59,681.33	26,018.67	69.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,654.10	110,836.29	1,817.81	98.39
210201	Тэтгэврийн даатгал	76,604.80	75,497.14	1,107.66	98.55
210202	Тэтгэмжийн даатгал	9,012.40	8,787.87	224.53	97.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,506.10	4,393.93	112.17	97.51
210204	Ажилгүйдлийн даатгал	4,506.10	4,393.93	112.17	97.51
210205	Эрүүл мэндийн даатгал	18,024.70	17,763.41	261.29	98.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	778,506.10	710,907.68	67,598.42	91.32
210301	Гэрэл, цахилгаан	130,463.20	103,882.77	26,580.43	79.63
210302	Түлш, халаалт	617,194.50	594,072.73	23,121.77	96.25
210303	Цэвэр, бохир ус	30,848.40	12,952.19	17,896.21	41.99
2104	Хангамж, бараа материалын зардал	71,390.60	58,313.00	13,077.60	81.68
210401	Бичиг хэрэг	8,151.70	6,210.95	1,940.75	76.19
210402	Тээвэр, шатахуун	33,040.00	25,056.44	7,983.56	75.84
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,930.30	4,438.29	492.01	90.02
210404	Ном, хэвлэл	592.00	448.00	144.00	75.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	22,156.60	20,230.67	1,925.93	91.31
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,520.00	1,928.65	591.35	76.53
2105	Нормативт зардал	800.00	535.00	265.00	66.88
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800.00	535.00	265.00	66.88
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	559,892.00	478,910.63	80,981.38	85.54
210601	Багаж, техник, хэрэгсэл	77,100.00	66,984.85	10,115.15	86.88
210602	Тавилга	8,500.00	3,610.00	4,890.00	42.47
210604	Урсгал засвар	474,292.00	408,315.78	65,976.23	86.09
2107	Томилолт, зочны зардал	22,950.00	20,199.80	2,750.20	88.02
210702	Дотоод албан томилолт	22,950.00	20,199.80	2,750.20	88.02
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	275,687.00	241,934.91	33,752.09	87.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	267,587.00	237,360.46	30,226.54	88.70
210803	Даатгалын үйлчилгээ	300.00	258.30	41.70	86.10
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,650.00	347.98	1,302.02	21.09
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	250.00	250.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	900.00	900.00	-	100.00
210807	Газрын төлбөр	3,500.00	1,318.18	2,181.83	37.66
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500.00	1,500.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,411.20	38,422.58	10,988.62	77.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,250.00	30,885.88	7,364.12	80.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,161.20	7,536.70	3,624.50	67.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,265.00	19,063.00	4,202.00	81.94
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	735.00	-	735.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	735.00	-	735.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,530.00	19,063.00	3,467.00	84.61
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,260.00	7,260.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,270.00	11,803.00	3,467.00	77.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	517,676.80	147,228.30	370,448.50	28.44
220001	Барилга байгууламж	78,000.00	49,000.00	29,000.00	62.82
223001	Бусад хөрөнгө	439,676.80	98,228.30	341,448.50	22.34
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	195,800.00	110,000.00	85,800.00	56.18
230001	Эргэж төлөгдөх зээл	195,800.00	110,000.00	85,800.00	56.18
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(2,389,841.50)	(217,303.46)	(2,172,538.04)	9.09
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,389,841.50	217,303.46	2,172,538.04	9.09
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	2,389,841.50	217,303.46	2,172,538.04	9.09
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	675,951.89	(675,951.89)	0.00

Архангай аймгийн Тариат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,197,200.16	(2,197,200.16)	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	28.00	29.00	(1.00)	103.57
620001	Удирдах ажилтан	12.00	12.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	-	1.00	(1.00)	0.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28.00	29.00	(1.00)	103.57
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	11.00	(1.00)	110.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00	-	100.00
650010	Гэрээт ажилтан	-	1.00	(1.00)	0.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	10.00	10.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант оны гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,903.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,903.73
122	Тусламжийн орлого	5,903.73
1221	Хандив тусламж /дотоод/	5,903.73
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,903.73
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,903.73
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,903.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,903.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,903.73
2104	Хангамж, бараа материалын зардал	1,973.20
210402	Тээвэр, шатахуун	1,763.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	210.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,930.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,930.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 29,016.7 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

- Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд 2-3 жилийн дараа төлөгдөх хүүгийн авлагыг урьдчилан тооцоо үүсгэж, 29,016.7 мянган төгрөгөөр авлагыг нэмэгдүүлж бүртгэснийг аудитын явцад залруулан тайлант онд хамаарах хүүгийн авлагаар бүртгүүлж, авлагыг бууруулан залруулав.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 20.2.4, 20.2.5 дахь заалтууд болон санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар залруулагдаагүй 19,190.9 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрч, аудитаас 2 албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайлангийн болон завсрын аудитаар илэрсэн зөрчлийн нөлөөллийг материаллаг бус гэж үнэлсэн. Харин төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн орон нутгийн тусгай сантай холбоотой 19,190.9 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлсэн бөгөөд аудитын төлөвлөлтийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын дүн **52,646.5** мянган төгрөгөөс бага байгаа тул сумын нэгдсэн тайланд **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Сумын ОНХС-ийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгахад Тариат сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Тариат сумын хавтгай оломын төмөр бетон гүүрний ажлын хяналтын зураг төсвийг шинэлэн боловсруулах" ажлыг 2,400.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн нь Сумын ИТХ-ын 2025 оны 07 дугаар 28-ны өдрийн "Сумын 2025 оны төсвийг тодотгон батлах тухай" 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт " ОНХС-ийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-д батлагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д "..., орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6-д "ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй", 4.7-д "Энэ зүйлийн 4.6-д зааснаар ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөхгүй зардалд дараах хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй" үүнд 4.7.5-д "..., орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.1.2. Сумын Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгахад Хоршоо хөгжүүлэх сангаас 2013-2020 онуудад зээл авсан 3 иргэнтэй холбоотой нийт 16,790.9 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлүүлэх талаар бодитой үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т "Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 10 дугаар зүйлийн 10.1-т “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина.”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХХС	1	29016.7			1	29016.7	1	29016.7				
Нийт дүн	1	29016.7			1	29016.7	1	29016.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ХХС	1	16790.9			1	16790.9						
ОНХС	1	2400.0			1	2400.0						
Нийт дүн	2	19190.9			2	19190.9						

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл													
												/мянган төгрөгөөр/	
Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ЗДТГ	2	153000.0			2	153000.0							
ЗДТГ-Завсрын аудит	2	1000.0			2	1000.0							
ХХС-завсрын аудит	1	43722.6			1	43722.6							
ЭМТ-тогтмол зардал	1	1437.5	1	1437.5									
ХХС	1	16790.9			1	16790.9							
ОНХС	1	2400.0			1	2400.0							
Нийт дүн	8	218351.0	1	1437.5	7	216913.5							